

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны
98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

**ХБТХОХ-ИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
Б.УУГАНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин /2023 он/	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Аймгийн бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх							
1.	1.1. Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд гол үүрэгтэй тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийг боловсруулан, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах	Хэрэгжилтийн хувь Тайлагнах хугацаа	96.2 хувь Хуулийн хугацаанд тайлагнасан	-	Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 95.5 хувьтай хэрэгжиж байна. Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах ажлын хэсгийг Засаг даргын 2025.03.13-ны А/202 дугаар захирамжаар баталсан. Боловсруулалт хийх дэд ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдэд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бодлогын баримт бичиг боловсруулах аргачлалын талаар мэдээлэл өгсөн. Ажлын хэсэг салбар бүрт тулгамдаж буй асуудлаа тодорхойлон, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийн, үндсэн	2025.01.02-2025.06.30	100%

					чиглэлийн төслийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулж байна.		
2.	1.2. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын зорилтыг аймгийн бодлогын баримт бичигт тусган хэрэгжилтийг зохион байгуулах	Тусгасан бодлогын баримт бичгийн тоо	1	-	“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тусгагдсан Зэс боловсруулах, металлурги- химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэр технологийн парк байгуулах, “Сургалт-Эрдэм шинжилгээ- Үйлдвэрлэлийн цогцолбор” хотхоныг байгуулах, Бүсийн тээвэр логикийн төвийг байгуулах, Аялал жуулчлалыг бүс орон нутгийн онцлогт түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлэх зэрэг зорилт, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.	2025.01.02-2025.06.30	100%
3.	1.3. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэх хүрээнд “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төсөлд тусгах саналыг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	Санал хүргүүлсэн байдал	-	Санал хүргүүлсэн байдал	“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Хойд бүсийн өргөтгөсөн хуралдааны үеэр болох Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанд хэлэлцүүлэх Бүсийн хөгжилтэй холбоотой 8 төслийн саналыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн уг төслүүдийн санал болон холбогдох мэдээллийг Хойд бүсээс сонгогдсон 8 гишүүн, Зам тээврийн яам, Боловсролын яам, Эдийн засаг, хөгжлийн яам болон Хойд бүсийн хөгжлийн төв ТББ-д албан бичиг хүргүүлсэн.	2025.01.02-2025.06.30	100%

4.	1.4. Аймгийн хэмжээнд баримтлах хөгжлийн жилийн төлөвлөгөөг аргачлал маягтын цагалварын дагуу боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх	Цагалварын дагуу төлөвлөх, хэрэгжилтийн хувь	Цагалварын хуваариар батлуулсан. 2024 оны хэрэгжилт 92.3%	Цагалварын дагуу, 2024 оны биелэлт 50-аас дээш хувь хэрэгжүүлнэ.	Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 05-р сарын 08-ны А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөө боловсруулах аргачлал”-ын цагалварын дагуу Орхон аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулан, мэргэжлийн байгууллагуудаас санал авах ажил хийгдэж байна. Эрдэнэт хотын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг гаргаж байна.	2025.01.02-2025.06.30	100%
5.	1.5. Аймгийн хэмжээнд баримтлах таван жилийн үндсэн чиглэл, хөгжлийн жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг unelgee.gov.mn сайтад шивж оруулах	01 дүгээр сард багтаах	Хуулийн хугацаанд гүйцэтгэсэн	01 дүгээр сард багтаан гүйцэтгэсэн байна.	unelgee.gov.mn сайтад 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 10 салбарын үр дүн, 21 ТЕЗ-ын үр дүн, 52 хөтөлбөрийн үр дүн, 181 арга хэмжээний хэрэгжилтийг гарган хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн хуулийн хугацаанд буюу 2025.03.17-ны өдөр 89.2%-тай тайлагнаж дууссан. Системд хараахан баталгаажуулалт хийгдээгүй байна. Мөн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 8 бүлгийн хүрээнд 8 салбарын үр дүн, 34 ТЕЗ-ын үр дүн, 63 хөтөлбөрийн үр дүн, 186 арга хэмжээг системд хуулийн хугацаанд оруулсан.	2025.01.02-2025.06.30	100%
6.	1.6. Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумдын хөгжлийн индексийн мэдээллийг 2024 оны байдлаар шинэчилж оруулах; www.lidi.nda.gov.mn	03 дугаар сард багтаах	Хуулийн хугацаанд гүйцэтгэсэн	03 дугаар сард багтаан гүйцэтгэсэн байна.	“Орон нутгийн хөгжлийн индекс” тооцох цахим систем өөрчлөгдөн https://ldi.regional.gov.mn/ болсон ба тус системд Баян-Өндөр, Жаргалант сумдын ерөнхий мэдээлэл болон индекс тооцох 31 төрлийн статистик	2025.01.02-2025.03.31	100%

					мэдээллийг хуулийн хугацаанд оруулуулан, хянаж баталгаажуулсан.		
7.	1.7. Бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргаас салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	Гэрээний хугацаанд тайлагнах Гүйцэтгэлийн хувь	Гэрээний хугацаанд тайлагнаж, гүйцэтгэл 96.4%-тай хэрэгжсэн.	Гэрээний хугацаанд, 50-аас дээш хувьтай биелүүлнэ.	Эдийн засаг, хөгжлийн сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 51.0%-ийн биелэлттэй хэрэгжсэн ба хяналт шинжилгээ, үзүүлэлт хийлгэхээр хүргүүлсэн.	2025.01.02-2025.06.30	100%
8.	1.8. Шинэ сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хангах, төвлөрөлийг сааруулах зорилтын хүрээнд 2025 оны төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэх	Хүн амын өсөлтийн хувь Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь	3.2 % 100 хувьтай хэрэгжүүлсэн.	2% -	Шинэ сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хэрэгжүүлэх Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих "Хамтдаа Эрдэнэтэд хөгжье" хөтөлбөрийн хүрээнд аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн багш нараас ахисан түвшний магистрын сургалтад 59 багшийг хамрууллаа. 2025 оны 5-р сарын 06-ны өдөр "Бүтээлч-Ухаалаг-Тогтвортой" уриан дор "Хойт бүс-Эрдэнэт-2025" эдийн засгийн форумыг зохион байгуулсан. Форумгаар Эрдэнэт хотыг 2036 он хүртэл хөгжүүлэх бодлогыг танилцуулан, Ухаалаг хот, Эрүүл оюунлаг хот, Цэвэр агаартай хот төслүүд, тэдгээрийн хүрээнд хэрэгжих 60 дэд төслийг танилцуулсан. Уг төслүүд хэрэгжсэнээр Орхон аймагт шилжин ирж буй иргэдэд бизнес эрхлэх, ажиллах, амьдрах таатай орчин бүрдэх юм.	2025.01.02-2025.06.30	50%

9.	1.9. Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах	Хэрэгжүүлэх ажлын тоо	2	1	Бүс, орон нутгийн бодлоготой холбоотой ЭЗХЯ болон холбогдох бусад байгууллагаас гарсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Эдийн засаг, хөгжлийн яамны сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу санал авч нэгтгэх ажил хийгдэж байна.	2025.01.02-2025.06.30	100%
Зорилт 2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах							
10.	2.1. Хэлтсийн хариуцах чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шийдвэр гаргуулахаар тавьсан асуудлыг судалж, шийдвэрлүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах	Гүйцэтгэлийн хувь	100%	50%	Хариуцах ажлын чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтан, иргэдээс шийдвэр гаргуулахаар тавьсан өргөдөл, хүсэл, албан бичгийг судалж, удирдлагуудыг мэдээллээр ханган, зөвлөгөө авч хариуг тухай бүр нь программд оруулан хааж байна. Төрийн үйлчилгээний харилцаа хандлагыг чухалчлан, хурдан шуурхай, чирэгдэлгүй үйлчилж байна.	2025.01.02-2025.06.30	100%
11.	2.2. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах	Гүйцэтгэлийн хувь	100%	50%	Удирдлагаас цаг үеийн шинжтэй, 7 хоногийн шуурхай хурлын, хэлтсийн шуурхай хурлуудаас өгөгдсөн үүрэг даалгавруудыг цаг хугацаанд нь биелүүлж, и-оффис программд биелэлтийг оруулан ажиллаж байна.	2025.01.02-2025.06.30	100%
12.	2.3. Аймгийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр холбогдох захирамжийг гаргуулан, хэрэгжилтийг хангах	Гүйцэтгэлийн хувь	100%	50%	Бүс, орон нутгийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр нийт 9 захирамж гарган 7 захирамжийг 100% хэрэгжүүлж, 2 захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2025.01.02-2025.06.30	100%

13.	2.4. Иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэн хариуг албан тоот болон биечлэн газар дээр нь очиж, утсаар хуулийн хугацаанд хурдан шуурхай, чирэгдэлгүй шийдвэрлэж ажилласан.	2025.01.02-2025.06.30	100%
14.	2.5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу батлагдсан мэдээ мэдээллийг нийтэд ил тод мэдээллэх	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу батлагдсан мэдээ мэдээллийг тухай бүр и-оффис программд оруулж, нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна. Орхон аймаг, Эрдэнэт хотын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлуулж и-оффис программд хугацаанд нь оруулж, Erdenet.mn сайтад байршуулсан.	2025.01.02-2025.06.30	100%
Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
1.	3.1.ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, хуулийн хугацаанд батлуулсан. Хууль тогтоомж, шийдвэрийн биелэлт, ЗГҮАХ-ийн биелэлтийг сар бүрийн 5-ны өдрийн дотор, хагас жилээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, ЗГҮАХ ЗДҮАХ, ТЖҮЧ, ХЖТ, ИТХ-ын тогтоол, шийдвэрийн биелэлт, ЭЗХС-тай байгуулсан гэрээний хэрэгжилт, Ерөнхий сайдтай байгуулсан Батламжийн биелэлт, бусад хугацаатай албан бичгийн мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.	2025.01.02-2025.06.30	100%
2.	3.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль,	Гүйцэтгэлийн хувь	100%	100%	Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган архив, албан	2025.01.02-2025.06.30	100%

	иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.				хэрэг хөтлөлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, чанарын удирдлагын тогтолцооны шаардлагад нийцүүлэн ажиллаж байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
3.	3.3.Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах	Хуулийн хугацаанд	Хуулийн хугацаанд мэдүүлсэн	02 дугаар сарын дотор	meduuleg.iaas.mn сайтад 2025 оны 02 дугаар сарын 10-ны дотор хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.	2025.02.10	100%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4		5		
Зорилт 1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1.	Байгууллагаас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэн үр дүнг уялдуулах	Хамрагдсан сургалтын тоо	4	2	1. Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүдэд зориулсан Ажлын байрны тодорхойлолт боловсруулах арга зүйн талаарх сургалтад хамрагдсан.	2025.01.02-2025.06.30	100%

					2. ЗДТГ-ын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан Ёс зүйн сургалтанд хамрагдсан 3. ЗДТГ-ын албан хаагчдад зохион байгуулсан Монгол хэл, бичгийн сургалтанд хамрагдсан		
2.	Удирлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгсөх	Төгссөн байдал	-	Амжилттай төгссөн байна	1. 2025 оны 03-р сарын 24-ны өдөр хүртэл Удирлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж амжилттай төгссөн, сертификат авсан.	2024.11.01-2025.03.24	100%
3.	Салбар яам болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөнд хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх	Хамрагдсан сургалтын тоо	4	1	1. Удирдлагын академиас зохион байгуулсан Төрийн захиргааны удирдах албан тушаалтны манлайлал сэдэвт сургалтад хамрагдан сертификат авсан. 2. "Монгол улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс" үндэсний чуулган болон Хяналт шинжилгээ-үнэлгээний журмыг танилцуулах сургалтад хамрагдсан.	2025.01.02-2025.06.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



/Б.УУГАНЦЭЦЭГ/

2025.06.06